



# СОЁМБО

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

# МЭЭДЭЭ

162 /162/

2021.10.22

## ҮЙЛ ЯВДАЛ

### МОНГОЛ, ГЕРМАНЫ ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ХАМТАРСАН УУЛЫН ЯВГАН ЦЭРГИЙН СУРГАЛТТАЙ ЕРӨНХИЙЛӨГЧ ТАНИЛЦАВ



Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч У.Хүрэлсүх өчигдөр Монгол Улс-Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын (ХБНГУ) Зэвсэгт хүчний хамтарсан Уулын явган цэргийн гуравдугаар шатны сургалтын үйл ажиллагаатай танилцлаа. Энэ үеэр Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, ХБНГУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Ёорн Розенберг, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, хошууч генерал Д.Ганзориг, ЯАБЗ-ийн нарийн бичгийн дарга Ж.Энхбаяр, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Аюулгүй байдал, батлан хамгаалахын бодлогын зөвлөх дэслэгч генерал Ц.Тогоо, Батлан хамгаалахын сайд асан Л.Болд, БХЯ-ны Гадаад хамтын ажиллагааны газрын дарга, хурандаа Б.Бат-Эрдэнэ, ТХЦК-ийн штабын дарга, хошууч генерал Л.Гансэлэм нар байлцлаа.

Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч Ухнаагийн Хүрэлсүх сургалтын үйл ажиллагаатай танилцсаныхаа дараа сургалтад оролцож буй бие бүрэлдэхүүнд хандан үг хэллээ. Тэрээр "Манай хоёр улсын батлан хамгаалах салбарын хамтын ажиллагаагаар дамжуулан бусад салбаруудын хамтын ажиллагааг харилцан

хөгжүүлж, иж бүрэн түншлэлийн түвшинд хүрсэн ололтыг бататган, харилцаа, хамтын ажиллагаагаа гүнзгийрүүлэхийн төлөөх үйл явцад батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчин маань манлайлан ажиллана гэдэгт миний бие итгэлтэй байна. Монгол Улсын Зэвсэгт хүчинтэй хамтран үүрэг гүйцэтгэж, монгол цэргийн нэр хүнд, мэргэжлийн ур чадвар, үүрэг гүйцэтгэлтийг дэлхийн тавцанд бататгах, мэргэжлийн цэрэгт суурилсан Зэвсэгт хүчний бүрдүүлж бэхжүүлэхэд тодорхой дэмжлэг үзүүлж буй ХБНГУ-ын Холбооны Батлан хамгаалах яам, түүний дотор ажиллагааны өмнөх бэлтгэлийг хамтран зохион байгуулж буй хөдөлгөөнт уулын явган цэргийн сургалтыг хамтран зохион байгуулж буй 23 дугаар уулын явган цэргийн бригадын удирдлага, бие бүрэлдэхүүнд тус тус халуун талархал илэрхийлж, сургалтын үйл ажиллагаанд амжилт хүсье" гэв.

Монгол Улсын Зэвсэгт хүчин, ХБНГУ-ын Зэвсэгт хүчний хамтарсан "Уулын явган цэргийн дунд шатны сургалт" 2021 оны 10 дугаар сарын 4-28-ны өдрүүдэд Монгол Улсын нутаг дэвсгэрт амжилттай зохион байгуулагдаж байна. Гурав дахь жилдээ зохион байгуулагдсан энэхүү сургалт хосолсон хэлбэрээр буюу Зэвсэгт хүчний Сургалтын нэгдсэн төвд

"Уулын явган цэргийн тактикийн ажиллагаа-буудлага", Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолбор газарт "Тактикийн ажиллагаа-хадан авиралт" гэсэн хөтөлбөрийн хүрээнд Зэвсэгт хүчний 331, 084 дүгээр ангиудын цэргийн алба хаагчид хамрагдаж байна. Сургалтыг ХБНГУ-ын Уулын явган цэргийн 23 дугаар бригадын Сургалтын хөдөлгөөнт бүлгийн дарга, дэд хурандаа Ё.Швеглер удирдан явуулж байгаа ба түүний хувьд 2019 оны анхан шатны сургалтыг мөн л удирдаж, монгол цэргүүдийг уулын тусгай хэрэгсэл ашиглан хаданд авирах, буух, бэхлэгээ хийх, эмнэлгийн татан гаргалт хийх арга техникийг заасан офицер юм.

Харин сургуулийн удирдагчаар Зэвсэгт хүчний 331 дүгээр ангийн штабын дарга, дэд хурандаа Х.Золжаргал, орлогчоор тус ангийн уулын бэлтгэлийн ахлах офицер ахмад Э.Энхбаатар нар томилогдон ажиллаж байгаа юм.

Энэ жилийн хамтарсан сургалтад Зэвсэгт хүчний 331 дүгээр ангид алба хааж буй долоон гэрээт цэрэг үүрэг гүйцэтгэж, уулын явган цэргийн сургалт бэлтгэлийг, анги салбаруудад бие даан явуулах нөхцөлийг бүрлүүлэх зорилгоор сургагч багшийн дамжаанд 12 офицер ахлагч бэлтгэж эхэлсэн зэргээрээ онцлогтой болж байгаа юм.

Монгол Улсын Зэвсэгт хүчний уулчин дайчдыг бэлтгэх үйлсэд хамгийн их үүрэгтэй оролцож буй ХБНГУ-ын Уулын явган цэргийн 23 дугаар бригадын Сургалтын хөдөлгөөнт бүлгийн дарга, дэд хурандаа Ё.Швеглертэй энэ хүрээнд сэтгэгдлээ хуваалцсан юм. Тэрээр "Нэн тэргүүнд манай сургалтын явцтай Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч У. Хүрэлсүх, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, ЗХЖШ-ын дарга, дэслэгч генерал Д.Ганзориг, ХБНГУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд ЁорнРозенберг нар хүрэлцэн ирж танилцсан нь нэр хүндийн асуудал юм. Сургалтын гол онцлог нь өнгөрсөн жилүүдэд явагдсан анхан болон дунд шатны сургалтыг хүндрүүлсэн. Өөрөөр хэлбэл, уулархаг газар районд байлдааны ажиллагаа явуулах чадварт сургасан. Уулын уруу буудах, өөдөө буудах гээд л. Монгол цэргүүд буудлагадаа үнэхээр сайн гэдгээ энэ удаад ч мөн баталж байна. Түүнчлэн Зэвсэгт хүчний 331, 084 дүгээр ангийн офицер, ахлагч нар дадлага, бэлтгэлээ сайн гүйцэтгэж ирсний хүчинд сургалт ямар ч түүртэх зүйлгүй амжилттай явагдаж байгаад талархаж буйгаа хэлэхэд таатай байна" гэлээ.

## АЖЛЫН ХЭСЭГ АНХДУГААР ХУРАЛДААНАА ХИЙЛЭЭ



Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч У.Хүрэлсүхийн 2021 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн 48 дугаар захирамжаар "Хугацаат цэргийн албаны нийгэмд үзүүлэх үр нөлөөг дээшлүүлэн, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх, бие бялдрын хүмүүжил олгох, мэргэжил, боловсрол эзэмшүүлэхэд чиглэсэн бодлого тодорхойлох, санал дүгнэлт боловсруулах" чиг үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдаж, өчигдөр анхдугаар хуралдаанаа хийлээ.

Энэхүү ажлын хэсгийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр ахалж байгаа бөгөөд бүрэлдэхүүнд

ЕТГ, ЯАБЗ, БХЯ, БШУЯ, ХНХЯ, ЗХЖШ, ХХЕГ, ЦЕГ, ОБЕГ, ШШГЕГ, ТЕГ, ТТХГ-аас удирдах албан тушаалтнууд багтсан юм.



Ургэлжлэл нь арын нүүрт!

## МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН 334.696 +1744	ЭДГЭРСЭН 453,036 +6064	НАС БАРСАН 1519 +16
-----------------------------------	---------------------------	------------------------

## ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН 5745 +98	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ 198	ЭДГЭРСЭН 5436
-----------------------------	----------------------------	------------------

## КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол Нийт: 242,324,272
Эдгэрсэн Нийт: 219,670,460
Нас барсан Нийт: 4,928,811

## Түүхэнд энэ өдөр

1918 он.

Монгол Улсыг төлөөлж Цэргийн яамны тамгыг хамаарсан дэд сайд Эрдэнэ чин ван, Орос Улсыг төлөөлж монгол цэргийн ахлах сургагч П.Толпыгин, Орлов, Буриад Абидаев нар монгол цэргийг сургах талаар хэлэлцээ байгуулав.

1931 он.

Бүх цэргийн мал эмнэлгийн дэргэд мал эмнэлгийн санитарын ба морь тахлах дархчуудын сургууль байгуулжээ.

## ЦАГ АГААР

### УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
9	-10

### ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
35	22

## ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,849.00	2,851.00
EUR	3,312.08	3,22.00
CNY	442.07	443.08
RUB	39.50	40.70
JPY	24.73	25.23
KRW	2.37	2.46

## ЗУРХАЙ

2021.10.22 БААСАН ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 17/

НАМРЫН АДАГ ШАР НОХОЙ САРЫН НЭГ ЦАГААН МЭНГЭТЭЙ ХАРАГЧИН ТУУЛАЙ ӨДӨР

Үс засуулбал:  
Өнгө зүс доройтно  
Өвчин ирнэ:  
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:  
07.22-17.52  
Барилдлага:  
Түлэх  
ШҮТЭН БАРИЛДЛАГА:  
Авахуй  
Суудал:  
Хий

Тухайн өдөр хонь, гахай жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр гэмт хэрэг илрүүлэх, гэм буруутныг шийтгэх, угаал үйлдэх, мал аж ахуйн үйл, удирдлагын суудалд суух, хийморийн дарцаг хатгахад сайн. Газар хагалах, ус булгийн эх малтах, уул овоо тахиад муу. Өдрийн сайн цаг нь хулгана, бар, туулай, морь, хонь, тахиа болой. Хол газар яваар одогсод ураги мөрөө гаргавал зохистой. Тэрсүүд өдөр. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

## АЖЛЫН ХЭСЭГ АНХДУГААР ХУРАЛДААНАА ХИЙЛЭЭ



### Түрүүч нь эхний нүүрт/

Ажлын хэсгийн гол зорилго нь хугацаат цэргийн албаны хэлбэр, алба хаах хугацаанд өөрчлөлт оруулах, тоог нэмэгдүүлэх, цаашид хэрхэн үр ашигтай байлгах вэ гэдэгт чиглэгдэж байгаа юм. Хурлын хүрээнд Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр "Угажлын хэсгийг "Бүтээлч" ажлын хэсэг байж, залуучууд руу чиглэсэн, иргэн цэргийн харилцааг бэхжүүлсэн, алба хаагчдад чанартай мэргэжлийн боловсрол олгох, цэргийн албанд залуус өөрийн хүсэл тэмүүлээрээ татагддаг байдлыг бий болгох шийдвэрүүд гаргана гэдэгт итгэж байна. Цэргийн алба гэдэг эр хүнийг бэлтгэхээс гадна эцэг хүнийг бэлтгэж байдаг. Тиймээс бид сургалтын системийг өөрчилж, хүн төвтэй, залууст насан туршид нь хэрэг болохуйц шийдвэрүүдийг гаргаж, бодит ажил болгохыг зорих болно" гэв.

Энэ үеэр ажлын хэсгийн гишүүд болох ХНХ-ын дэд сайд С.Зулпхар, БШУ-ны дэд сайд Г.Ганбаяр хэд хэдэн бодлогын саналуудыг оруулж ирсэн юм. Тодруулбал, залуусыг хугацаат цэргийн алба хааж байх хугацаандаа Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийг түшиглэн энгийн мэргэжил эзэмшүүлэх, хувь хүний хөгжил, гэр бүл төлөвлөлт, хөдөлмөрийн харилцаанд оролцох шаардлагатай ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтуудыг зохион байгуулах зэрэг байлаа.

Түүнчлэн энэ намрын чуулганаар БШУЯ-аас Боловсролын тухай багц хуулийн төсөл өргөн барьж байгаа бөгөөд тус хуульд Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн хөтөлбөрт сурагчдад цэрэг-эх оронч үзэл, хүмүүжил


олгохоор тусгасан нь бидний өнгөрсөн хугацаанд хийж хэрэгжүүлсэн ажил хөрсөн дээр буух боломж бүрдэх боломжтой бөгөөд энэ нь залуу хойч үедээ оюунд нь "Монгол дархлаа"-г өвлүүлэн үлдээх том ажил болох талаар энд дурдагдав.

Үүгээр ч зогсохгүй БШУЯ, ЗХЖШ-тай хамтран их дээд сургуулиудад "Цэргийн эрдмийн тэнхим" байгуулах, хугацаат цэргийн алба хаагчдад монгол, англи хэл, мэдээлэл зүйн хичээлүүдийг тухайн аймаг, нийслэлийн Боловсролын газартай хамтран хэрэгжүүлэх боломж байгааг энэ үеэр хуралд оролцогсод хэлж байв.

Төгсгөлд нь Батлан хамгаалахын сайд "Мөрөөдлийн жагсаалт гаргах бус бодит ажил болгох, иргэндээ хэрэгтэй шийдвэрүүдийг гаргах нь чухал" гэдгийг ажлын хэсгийн гишүүдэд хэллээ.

### Цахим шууданд

## "ТЭМҮҮЖИН-ӨРЛӨГ" ОРОС ХЭЛНИЙ КАБИНЕТТАЙ БОЛЛОО



Энэ сарын 21-ны өдөр "Тэмүүжин-Өрлөг" сургуулийг түшиглэн орос хэлний төв, кабинет байгуулахаар Монгол Улс дахь ОХУ-ын Элчин сайдын яамны зөвлөх, Монгол Улс дахь россотрудничество агентлагийн төлөөлөгчийн газрын тэргүүн, Улаанбаатар дахь "Русский дом"-ын

захирал Базархандаев Амгалан Ринчинович, Баянзүрх дүүргийн боловсролын хэлтсийн дарга Б.Ганбат, Нийслэлийн тэргүүний Тэмүүжин-Өрлөг сургуулийн захирал, дэд хурандаа Д.Бат-Эрдэнэ нар хамтын ажиллагааны хэлэлцээр байгууллаа.

Мөн энэ үеэр Тэмүүжин-Өрлөг сургуулийн сургалтын орчин сайжруулах зорилгоор орос хэлний сурах бичиг, уран зохиолын ном сургалтын бусад материал бэлэглэв. Цаашид тус байгууллагууд хамтын ажиллагаагаа өргөжүүлж хамтран ажиллахаа илэрхийллээ.

## СУРГУУЛИЙН ЖИЛИЙН НЭЭЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХҮНДЭТГЭЛИЙН АРГА ХЭМЖЭЭТЭЙ ХАМТАТГАВ



**Зэвсэгт хүчний 120 дугаар анги** 2021-2022 оны сургуулийн жилийн нээлтийн үйл ажиллагааг ангийн удирдлага, штабын офицерууд, салаа салбарын захирагч нар болон даргалах албан тушаалын ахлагч нартай явуулах заах аргын цугларалтын хамт амжилттай зохион байгууллаа.

Энэ жил Монгол Улсад орчин цагийн Артиллерийн

цэрэг үүсэн байгуулагдсаны түүхт 100 жилийн ой тохиож байгаа ба тус сургуулийн жилийн нээлтийн үйл ажиллагааны дараагаар Монгол улсын баатар хурандаа генерал Бутачийн Цогийн хөшөөнд цэцэг өргөх ёслолын ажиллагаа болж өндөрлөлөө. Уг цэцэг өргөх ёслолд Монголын Артиллерийн цэргийн холбооны ерөнхийлөгч, хошууч генерал Б.Баярмагнай

болон Ардын армийн 019, 120 дугаар ангийн үе үеийн захирагч, удирдлагууд болон артиллерийн цэргийн ахмад дайчид оролцсон юм.

Энэ үеэр ахмад дайчдыг ангийн өдөр тутмын үйл ажиллагаа, байр орон сууц, артиллерийн зэвсэглэл техниктэй танилцуулан хүндэтгэлийн зоог барьснаар арга хэмжээ амжилттай болж өндөрлөлөө.

**Дэслэгч Б.БАТТУЛГА**



### Цахим шууданд

## АНГИЙН 2021-2022 ОНЫ СУРГУУЛИЙН ЖИЛИЙГ НЭЭЛЭЭ



үйлчилгээтэй шинэ дугаар өгөх үйл ажиллагааг "Мобиком" ХХК-тай хамтран зохион байгууллаа. Энэ үеэр "Мобиком" ХХК-аас дугаар авсан хугацаат цэргийн алба хаагчдад 2022 оны 06-р сарыг дуустал сар бүр 10GB дата авах урамшууллын эрх бэлэглэв. Мөн "МУИС"-ийн маркетингийн албаны дарга Ц.Отгонбанди болон тус сургуулийн төлөөлөл, Зэвсэгт хүчний 014 дүгээр ангид 10 дугаар сарын 13-ны өдөр ирж хугацаат цэргээсээ халагдах дайчдад зориулан цэргийн албанаас бэлтгэлээр халагдсаны дараах мэргэжил сонголт болон хувь хүний хөгжил, амжилтын талаар яриа хийв. Түүнчлэн халагдсан цэргүүд өөрийн сонирхол, чадавх болон зах зээлийн эрэлтийг харгалзан ажил, мэргэжлээ сонгож, сурч эзэмших, ажил мэргэжлээрээ тасралтгүй өсөж хөгжихөд нь шаардлагатай мэдээлэл, зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх замаар тогтвортой ажлын байраар хангах, зуучлах зэрэг хэрэгцээтэй мэдээ мэдээллээр яриа, таниулга хийлээ. Төгсгөлд нь "Дэвжих" хөдөлмөрийн биржээс зөвлөгөө авах хүсэлтэй хугацаат цэргийн алба хаагчдад нэрийн хуудас, боршур, тараан бүртгэж авсан юм. Дээрх ажиллагаануудыг "СО-VID-19" цар тахлаас урьдчилан сэргийлэх зөвлөмжийн дагуу халдвар хамгааллын дэглэмийг сахиулан хоорондын зай барих, ариутгал халдваргүйжүүлэлтийн арга хэмжээг авч хамрагдлаа.

**Дэслэгч Р.БИЛЭГ**

### Зэвсэгт хүчний 014 дүгээр анги

2021-2022 оны сургуулийн жилийн нээлтийн үйл ажиллагаа амжилттай явагдаж өндөрлөлөө. Ангийн захирагч, хурандаа Г.Эрдэнэбаатар, ХЗЦК-ийн инженерийн дарга, дэд хурандаа Г.Мөнхбат нар сургуулийн жилийг нээж бие бүрэлдэхүүнд хандан үг хэлж, баяр хүргэсэн юм.

Сургуулийн жилийн нээлтэд зориулан ангийн инженерийн тагнуулын салааны

захирагч, дэслэгч Б.Баяртогтох ая дууны мэндчилгээ дэвшүүлсэн нь олны талархлын хүлээв. Үргэлжлүүлээд ангийн нийт бие бүрэлдэхүүн ёслолын жагсаалаар алхаж хүндэтгэл үзүүлээ.

Мөн тус анги 2020-2021 онд цэргийн алба хаасан хугацаат цэргийн алба хаагчдад зориулж дараа төлбөрт болон хосолсон төлбөрт